



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2005 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Эрчим хүчний салбарт мөрдөх дансны
жагсаалт, заавар батлах тухай

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрчим хүчний салбарт мөрдөх дансны жагсаалт, дансны заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан дансны жагсаалт, дансны зааврыг 2005 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид мөрдүүлэхээр тогтоосугай.

3. Энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргазүйн хэлтэс /Л.Дондог/-т даалгасугай.



 Н.АЛТАНХУЯГ



Сангийн Сайдын 2005 оны
07 тоот тушаалаар батлав.

**МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ НЭГДСЭН ЖАГСААЛТЫН ЗААВАР**

1. Дансны нэгдсэн жагсаалтын үндэслэл, зорилго

Эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх дансны нэгдсэн жагсаалт, дансны зааврыг СЭЗС-ын 2000 оны 116 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавартай нийцүүлэн боловсруулав.

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу дансны нэгдсэн жагсаалтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай нийцүүлсэн тул үүнийг мөрдсөнөөр эрчим хүчний салбарт олон улсын стандарт нэвтрэх боломжтой юм.

2. Дансны нэгдсэн жагсаалтын бүтэц

Дансны нэгдсэн жагсаалт нь баланс ба орлого, үр дүнгийн тайлангийн дансуудаас бүрдэнэ. Баланс нь хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмч гэсэн байнгын дансууд, орлого үр дүнгийн тайлан нь тайлант хугацааны эцэст орлого, зардлын нэгдсэн дансанд хаагдах түр дансуудыг агуулна.

Дансны нэгдсэн жагсаалтын дансны дугаар нь 5 оронтой бөгөөд эхний 2 орон нь СЭЗС-ын 2000 оны 116 тоот тушаалаар баталсан дансны жагсаалтын кодтой ижил байна. Дэд дансыг аж ахуйн нэгж бүр өөрийн хэрэгцээнд нийцүүлэн мөрдөнө.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1. Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагууд нь энэхүү дансны жагсаалт, дансны зааврыг ашиглан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэнэ.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.
3. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн байна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан дансны жагсаалтыг энэхүү дансны нэгдсэн жагсаалтад тулгуурлан бэлтгэнэ.
5. Дансны нэгдсэн жагсаалтын заавар нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

1. Ерөнхий зүйл
2. Хөрөнгийн бүртгэл
3. Өр төлбөрийн бүртгэл
4. Эзэмшигчийн өмчийн бүртгэл
5. Орлогын бүртгэл
6. Зардлын бүртгэл

Эдгээр зургаан үндсэн бүлгээс заавар бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь дотроо дэд хэсгүүдэд хуваагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүн болон бизнест өгөөж бий болгохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн өгөөж байдлаар аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа нөөц болно. Нягтлан бодох бүртгэлд хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус гэж ангилна.

А. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны цикл ба 1 жилийн аль уртад нь эсвэл 1 жилийн дотор хэвийн үйл ажиллагаанд зарцуулах болон бусад зориулалтаар ашиглах мөнгөн хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт, дансны авлага, урьдчилж төлсөн төлбөр, бараа материал нь эргэлтийн хөрөнгөнд хамрагдана.

1. Мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгө

1.1 Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь байгууллагын кассанд байгаа болон банканд байгаа төгрөг, валют болон бусад мөнгөтэй адилтгах зүйлсээс бүрдэнэ. Эдгээрийг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

10 000 Касс дахь бэлэн мөнгө: Бэлэн мөнгийг төрлөөр нь дараах дансуудад бүртгэнэ.

10 100 - Төгрөг
10 200 - Доллар
10 300 - Евро
10 400 - Бусад бэлэн мөнгө

11 000 Харилцах дахь мөнгө: Банкны харилцах дансанд байгаа мөнгийг дараах дансуудад бүртгэнэ.

11 100 - Төгрөг
11 200 - Доллар
11 300 - Евро
11 400 - Бусад мөнгө

1.2 Үнэлгээ: Мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэх ба гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэнэ.

1.3 Бүртгэл: Мөнгөн хөрөнгө нь гол төлөв аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанаас олох орлого, төлбөрөөс бүрдэнэ. Жишээ нь:

Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дамжуулах компанид бэлнээр борлуулалт хийвэл:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого

Хэрэглэгч урьдчилсан төлбөр хийвэл:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Урьдчилж орсон орлого

Бэлэн мөнгөөр түлш, түүхий эд материал худалдан авахад:

Дт Түлш: Нүүрс
Кт Мөнгөн хөрөнгө

Цалин, бичиг хэрэг, хангамжийн зүйлс, татвар гэх мэт мөнгөн зарлага гарвал:

Дт Зардлын холбогдох данс
Кт Мөнгөн хөрөнгө

Ажилтан албан хаагчдын томилолт болон няравт бараа материал бэлтгэхэд нь урьдчилгаа олговол:

Дт Ажилтан албан хаагчдын цалингаас бусад урьдчилгаа
Кт Мөнгөн хөрөнгө

2. Авлага

2.1 Авлага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын худалдааны ба худалдааны бус авлагаас бүрдэнэ. Худалдааны авлагыг дансны нэгдсэн жагсаалт дахь дансуудад хэрэглэгчдийн ангиллаар бүртгэнэ. Үүнд ирээдүйд батлагдах 2 шатлалтай (энергийн, чадлын) тарифын аргачлалыг дэмжсэн дансууд орно. Худалдааны бус авлагыг байгууллагын дотоод авлага, гадаадын байгууллагаас авах авлага, удирдлага болон холбоотой талуудын авлага гэх мэт дансуудад бүртгэнэ.

12 110 - Хэрэглэгч: Оршин суугч, ахуйн хэрэглэгчид
12 120 - Хэрэглэгч: Худалдаа, үйлчилгээний байгууллага
12 121 - Худалдаа, үйлчилгээний байгууллага-400В
12 122 - Худалдаа, үйлчилгээний байгууллага-10/6КВ
12 130 - Хэрэглэгч: Үйлдвэрлэлийн байгууллага
12 131 - Үйлдвэрлэлийн байгууллага-400В
12 132 - Үйлдвэрлэлийн байгууллага-10/6КВ
12 133 - Үйлдвэрлэлийн байгууллага-35КВ
12 140 - Хэрэглэгч: Төсвийн байгууллага
12 210 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч
12 211 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн чадлын борлуулалт
12 212 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энергийн борлуулалт
12 213 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дулааны борлуулалт
12 220 - Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч
12 310 - Ажилтан албан хаагчдын цалингаас бусад урьдчилгаа
12 320 - Ажилтан албан хаагчдын цалингийн урьдчилгаа
12 350 - Удирдлагын авлага
12 400 - Холбоотой компаниудын авлага
12 500 - Байгууллагын дотоод авлага
12 600 - Гадаадын байгууллагын авлага
12 700 - Бусад авлага
12 800 - Нэмэгдсэн өртгийн албан татварын авлага
12 900 - Найдваргүй авлагын хасагдуулга

2.2 Үнэлгээ: Авлагыг найдваргүй авлагын хасагдуулга /нөөц/-ыг хассан дүнгээр балансад тусгана.

2.3 Бүртгэл: Худалдааны ба худалдааны бус авлагыг бүртгэх жишээг үзүүлэв.

Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч цахилгаан, дулаанаа дараа тооцоогоор борлуулсан нөхцөлд:

Дт Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч (дансны авлага)
Кт Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого

Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч цахилгаан, дулаанаа хөнгөлөлттэй борлуулсан нөхцөлд:

Дт Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч (дансны авлага)
Борлуулалтын хөнгөлөлт
Кт Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого

Найдваргүй авлагын нөөцийг байгуулах:

Дт Найдваргүй авлагын зардал
Кт Найдваргүй авлагын хасагдуулга

Найдваргүй авлагыг данснаас хасах:

Дт Найдваргүй авлагын хасагдуулга
Кт Дансны авлага

3. Богино хугацаат хөрөнгө оруулалт

3.1 Тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан илүүдэл мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор хугацаат хадгаламж, түргэн борлогдох үнэт цаас зэрэгт зарцуулж байгаа үйл ажиллагааг богино хугацаат хөрөнгө оруулалт гэнэ. Үүнийг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

13 100 - Түргэн борлогдох үнэт цаас
13 200 - Векселийн авлага
13 300 - Засгийн газрын үнэт цаас
13 400 - Бусад богино хугацаат хөрөнгө оруулалт
13 500 - Урт хугацаат хөрөнгө оруулалтын богино хугацаат хэсэг
13 900 - Богино хугацаат хөрөнгө оруулалтын хасагдуулга

3.2 Үнэлгээ: Богино хугацаат хөрөнгө оруулалтыг анх худалдан авсан өртгөөр нь бүртгэх ба өртөг зах зээлийн аль бага үнээр нь санхүүгийн тайланд тусгана. Богино хугацаат хөрөнгө оруулалтыг багцынх нь хувьд дансны үнэ, зах зээлийн үнийг харьцуулан өртөг буюу дансны үнийн зах зээлийн үнээс давсан зөрүүг үнэлгээний хасагдуулга байдлаар бүртгэж тайлагнана.

3.3 Бүртгэл: Богино хугацаат хөрөнгө оруулалтын жишээг үзүүлэв.

Түргэн борлогдох үнэт цаас худалдан авбал:

Дт Түргэн борлогдох үнэт цаас
Кт Мөнгөн хөрөнгө

Хүүгийн орлого:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Хүүгийн орлого

Түргэн борлогдох үнэт цаасыг худалдан борлуулснаас үүссэн ашгийн дүнгээр:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Түргэн борлогдох үнэт цаас борлуулсны ашиг
Түргэн борлогдох үнэт цаас

Түргэн борлогдох үнэт цаасны нэгдсэн өртөг нэгдсэн зах зээлийн үнээс илүү бол:

Дт Түргэн борлогдох үнэт цаасны зах зээлийн үнийн бууралтын гарз
Кт Богино хугацаат хөрөнгө оруулалтын хасагдуулга

4. Бараа материал

4.1 Бизнесийн мөн чанараас хамааран бараа материалд хамаарах зүйлсийг тодорхойлдог. Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагын бараа материал нь түлш, мазут зэрэг үндсэн түүхий эд, химийн бодис, шатах тослох материал, хангамжийн материал, үйлдвэрлэлийн болон тээврийн сэлбэг хэрэгслүүдээс бүрдэнэ.

Бараа материалын нэг хэсэг бол аваарын нөөц юм. Энэ нь байгалийн гамшиг мэт гэнэтийн шаардлагатай үед үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах зайлшгүй нөөцөд байх сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал юм.

4.2 Үнэлгээ: Бараа материалын өртөг нь түүнийг худалдан авахад гарсан зардал, дахин боловсруулалтын өртөг буюу бараа материалыг одоогийн байдалд оруулахтай

холбогдон гарсан шууд ба шууд бус зардлыг багтаасан байна. Худалдан авахад гарсан зардалд бараа материалыг худалдан авсан үнэ, үйлчилгээний төлбөр, тээврийн зардал, импорт, гаалийн ба онцгой татвар зэрэг хамаарна.

Мөн бараа материалыг худалдан авахтай холбогдон гарсан өөр бусад зардал тухайлбал, худалдааны шимтгэл, барааг хүлээн авах, ачиж буулгах, хадгалахтай холбогдон гарсан зардлыг худалдан авсан өртөгт оруулна. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байгууллагын хувьд бараа материалын өртөгт татварын зардал орохгүй. Бараа материалыг дараах дансуудад бүртгэнэ.

- 14 110 - Түлш: Нүүрс (үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн түүхий эд)
- 14 120 - Түлш: Мазут (үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн түүхий эд)
- 14 200 - Үндсэн сэлбэг хэрэгсэл (үндсэн тоног төхөөрөмж, тоноглолын сэлбэг хэрэгсэл)
- 14 300 - Багаж хэрэгсэл (багаж хэрэгслийн шинж чанартай зүйлс)
- 14 400 - Хангамжийн материал (хангамж, үйлчилгээний материал)
- 14 510 - Шатахуун ба шингэн түлш (бензин, дизель болон бусад шингэн түлш)
- 14 520 - Тосолгооны материал (тослох материал)
- 14 600 - Тээврийн хэрэгслийн сэлбэг (авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг)
- 14 700 - Химийн материал (химийн бодис, лабораторийн материал)
- 14 800 - Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа (хөдөлмөр хамгааллын хувцас болон бусад хамгаалах хэрэгсэл)
- 14 900 - Бусад бараа материал (дээрх ангилалд хамаарахгүй бараа материал)

4.3 Бүртгэл: Бараа материалын бүртгэлийн жишээг үзүүлэв.

Түүхий эд, бусад хангамжийн зүйлсийг өртгөөр:

Дт	Түлш: Нүүрс / бусад хангамжийн зүйлс
Кт	Дансны өглөг / Мөнгөн хөрөнгө

Үндсэн сэлбэг хэрэгслийг зарлага болгож буй хэмжээгээр:

Дт	Үйлдвэрлэлийн зардал (үйлдвэрлэлийн цех бүрийн дансны дебетэд)
Кт	Үндсэн сэлбэг хэрэгсэл

Үйлдвэрлэлийн бус зориулалтаар зарлага болгож буй хэмжээгээр:

Дт	Удирдлагын зардал (зардлын холбогдох данс бүрийн дебетэд)
Кт	Хангамжийн материал

Бараа материалыг ашиг гарган худалдан борлуулсан нөхцөлд:

Дт	Мөнгөн хөрөнгө / бусад авлага
Кт	Бараа материал (бараа материалын холбогдох данс) Бараа материал худалдан борлуулсны ашиг

5. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

5.1 Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлуудыг үүнд бүртгэнэ. Энэ нь төлбөр хийгдсэн боловч тайлант хугацаанд гараагүй байгаа зардал учраас хөрөнгө юм. Урьдчилж төлсөн зардал/тооцоог дараах дансуудад бүртгэнэ.

- 18 100 - Урьдчилж төлсөн зардал (урьдчилж төлсөн түрээс, даатгал г.м)
- 18 200 - Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын урьдчилгаа
- 18 210 - Хүн амын орлогын албан татварын урьдчилгаа
- 18 230 - Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын урьдчилгаа
- 18 240 - Бусад татварын урьдчилгаа (дээрх татвараас бусад татвар)
- 18 300 - Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа
- 18 400 - Бусад урьдчилж төлсөн зардал, тооцоо (дээрх жагсаалтаас бусад зүйлс)

5.2 Үнэлгээ: Урьдчилж төлсөн зардал/тооцоог төлөгдсөн хэмжээгээр бүртгэнэ.

5.3 Бүртгэл: Урьдчилж төлсөн зардал/гооцоог бүртгэх жишээг үзүүлэв.

Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа ба урьдчилан гарсан зардлыг:

Дт	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа
Кт	Мөнгөн хөрөнгө

Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа ба урьдчилж гарсан зардлыг тайлангийн үед ногдох хэмжээгээр:

Дт	Бараа материал
Кт	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа

Татварын урьдчилгаа төлбөр хийвэл:

Дт	Бусад татварын урьдчилгаа
Кт	Мөнгөн хөрөнгө

Татварын урьдчилж гарсан зардлыг тайлангийн үед ногдох хэмжээгээр:

Дт	Татварын зардал (холбогдох зардлын данс)
Кт	Бусад татварын урьдчилгаа

Б. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Эргэлтийн бус хөрөнгөд аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд нэг жил буюу түүнээс дээш хугацаагаар ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал, үйлдвэрлэл, үйлчилгээний болон удирдлага захиргааны зориулалтаар ашиглах үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт гэх мэт хөрөнгүүд хамрагдана.

6. Үндсэн хөрөнгө

6.1 Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, худалдах зориулалтгүй, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх/хангах үйл ажиллагаа, эрчим хүч борлуулалтын үйл ажиллагаа болон удирдлага, захиргааны зориулалтаар ашиглагддаг элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгүүд байна. Үндсэн хөрөнгийг дансны нэгдсэн жагсаалтад дараах байдлаар ангилсан.

- а. Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгө
- б. Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгө

Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгө: Энэхүү ангилалд үйлдвэрлэх түгээх/хангах, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгддэг биет хөрөнгүүд орно. Үүнд:

- 20 100 - Газар ба газрын эрх
- 20 200 - Барилга байгууламж
- 20 210 - Зуухны тоног төхөөрөмж
- 20 220 - Хөдөлгүүр ба хөдөлгүүрээр ажилладаг генератор
- 20 230 - Турбин ба генератор
- 20 240 - Цахилгаан тоног төхөөрөмж
- 20 250 - Цахилгаан станцын бусад тоног төхөөрөмж
- 20 260 - Усан сан, далан, ус дамжуулах тоног төхөөрөмж
- 20 270 - Төмөр зам, зам, гүүр
- 20 280 - Түлш агуулах, боловсруулах хэрэгсэл
- 20 290 - Дизель генератор
- 20 300 - Дэд станцын тоног төхөөрөмж
- 20 310 - Шонгийн мод цамхаг ба хэрэгсэл
- 20 320 - Цахилгаан дамжуулах шугам, төхөөрөмж
- 20 330 - Газар доогуур шугамын хоолой, уурын хоолой
- 20 340 - Газар доогуур цахилгаан дамжуулах шугам, төхөөрөмж

- 20 350 - Шугамын трансформатор
- 20 360 - Суурилуулах үйлчилгээний тоног төхөөрөмж
- 20 370 - Тоолуур, хэмжих хэрэгсэл
- 20 380 - Хэрэглэгчийн байршилд суурилуулалт хийх тоног төхөөрөмж
- 20 400 - Дуусаагүй барилга

Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгө: Үндсэн үйлдвэрлэлд туслах шинж чанартай ашиглагддаг хөрөнгүүдийг дараах дансуудад бүртгэнэ.

- 20 500 - Газар ба газрын эрх
- 20 510 - Барилга байгууламж
- 20 520 - Тавилга эд хогшил
- 20 530 - Тээврийн хэрэгсэл
- 20 540 - Агуулахын тоног төхөөрөмж
- 20 550 - Багаж хэрэгсэл, засварын газар, гаражийн тоног төхөөрөмж
- 20 560 - Лабораторийн тоног төхөөрөмж
- 20 570 - Цахилгааны тоног төхөөрөмж
- 20 580 - Холбооны тоног төхөөрөмж
- 20 590 - Бусад ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгө

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өөрийн мэдээллийн хэрэгцээ болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн дэд дансуудыг дансны төлөвлөгөөндөө нэмж ашиглана.

6.2 Үнэлгээ: Үндсэн хөрөнгө нь анхны өртөг, эсхүл дахин үнэлсэн үнээс хуримтлагдсан элэгдлийг хасаж тооцсон үлдэгдэл өртгөөр нь илэрхийлэгдэнэ.

Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй болон барьж байгуулахтай холбогдон гарсан аливаа шууд зардал тухайлбал, тээврийн зардал, гаалийн татвар, хураамж, угсарч суурилуулах, ачиж буулгах зардал, гэрээгээр гүйцэтгэгчид төлсөн төлбөр, шууд материал, ерөнхий болон удирдлагын зардал, тусгай зөвшөөрөл, инженерийн үйлчилгээ, тухайн хөрөнгийг барьж байгуулах хүртэлх хугацаанд хуваарилагдсан зээлийн хүү зэрэг зардлууд орно.

Газар ба газрын сайжруулалтыг худалдан авбал, гарсан зардлыг газар ба сайжруулалтад хуваарилна. Газар дээрх барилгыг нураах зардлыг газрын өртөг дээр нэмэх ба үлдэгдэл зүйлсийг борлуулсан мөнгөн орлогын хэмжээгээр газрын өртгийг багасгана.

Мөнгөн бус солилцоогоор үндсэн хөрөнгө худалдан авбал солилцоогоор шилжүүлсэн хөрөнгийн зах зээлийн үнээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

Хувьцаа болон бусад үнэт цаасны солилцоогоор хөрөнгийг худалдан авсан бол хүлээн авсан хөрөнгө буюу гаргасан хувьцааны аль тодорхой нотлогдох зах зээлийн үнээр бүртгэнэ. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын явцад гардаг сайжруулах, өөрчлөх, сэргээн босгох, их засвар хийхтэй холбогдон гарсан зардлуудын тухайн хөрөнгийг анх үнэлэх үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайн хөрөнгөөс хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх тухайлбал, ашиглах хугацааг уртасгах зардлууд нь өртөг дээр нэмэгдэх ёстой. Бусад бүх зардлууд нь тайлангийн хугацааны зардал болно.

6.3 Бүртгэл: Үндсэн хөрөнгийг бүртгэх жишээг үзүүлэв.

Үндсэн хөрөнгийг бэлэн мөнгөөр, эсхүл дараа тооцоогоор худалдан авсан бол:

- Дт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)
- Кт Мөнгөн хөрөнгө / дансны өглөг

Үндсэн хөрөнгийг урт хугацаат зээлээр олж бэлтгэсэн бол:

- Дт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)

Кт Урт хугацаат зээл

Их засварын зардлыг гүйцэтгэлээр нь капиталжуулах бол:

Дт Үндсэн хөрөнгө
Кт Их засварын зардал (холбогдох зардлын данс)

Үндсэн хөрөнгийн урсгал засварын зардлыг:

Дт Урсгал засварын зардал (холбогдох засвар үйлчилгээний зардлын данс)
Кт Мөнгөн хөрөнгө / дансны өглөг

Үндсэн хөрөнгийн тайлангийн үеийн элэгдлийн зардлыг:

Дт Элэгдлийн зардал
Кт Хуримтлагдсан элэгдэл

Хуримтлагдсан элэгдлээр өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасвал:

Дт Хуримтлагдсан элэгдэл
Кт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)

Үндсэн хөрөнгийг дансны үнээс нь дээгүүр үнээр борлуулбал:

Дт Мөнгөн хөрөнгө / бусад авлага
Хуримтлагдсан элэгдэл
Кт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)
Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг

Үндсэн хөрөнгийг дансны үнээс нь доогуур үнээр борлуулбал:

Дт Мөнгөн хөрөнгө / бусад авлага
Хуримтлагдсан элэгдэл
Үндсэн хөрөнгө борлуулсны алдагдал
Кт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)

Үнэ цэнийн бууралтыг тусгахдаа:

Дт Үнэ цэнийн бууралтын алдагдал
Кт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)

Дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэхдээ:

Дт Үндсэн хөрөнгө (холбогдох хөрөнгийн данс)
Кт Дахин үнэлгээний нэмэгдэл

7. Биет бус хөрөнгө

7.1 Үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний нийлүүлэлтээс бусад, түрээслэх эсвэл удирдлагын зорилгоор ашиглагдах биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц мөнгөн бус хөрөнгийг биет бус хөрөнгө гэнэ. Үүнд патент, гудвилл, франчайз, зохиогчийн эрх, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон харилцаа холбооны програм хангамж зэрэг хөрөнгүүд орно. Биет бус хөрөнгийг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

- 21 100 - Гудвилл
- 21 200 - Патент
- 21 300 - Зохиогчийн эрх, барааны тэмдэг
- 21 400 - Лиценз
- 21 500 - Компьютерийн програм хангамж
- 21 600 - Бусад биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг өртгөөс тусад нь үндсэн хөрөнгийн нэг адил хуримтлагдсан элэгдэл дансаар бүртгэнэ.

7.2 Үнэлгээ: Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авсан өдөр өртгөөр нь бүртгэнэ. Өртөг нь төлсөн мөнгөний дүн, өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ, гарсан өр төлбөрт төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл хувьцаа гаргалтын хувьд хүлээн авсан зах зээлийн үнэ цэнээр хэмжигддэг.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд судалгаа хөгжүүлэлтийн зардлаас бусад өртөг зардлыг биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулдаг. Дотоодод бий болсон гудвиллыг хөрөнгө гэж бүртгэхгүй.

Биет бус хөрөнгийг хувьцаа болон өөр бусад мөнгөн бус солилцоо хийх замаар олж бэлтгэж болно.Энэ тохиолдолд биет бус хөрөнгийн өртгийг шилжүүлэн өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ хоёрын аль тодорхой байгаа үнээр үнэлнэ.

7.3 Бүртгэл: Биет бус хөрөнгийг бүртгэх жишээг үзүүлэв.

Биет бус хөрөнгө болох компьютерийн програм худалдан авсан бол:

Дт Компьютерийн програм хангамж
Кт Мөнгөн хөрөнгө / дансны өглөг

Биет бус хөрөнгийн тайлангийн үеийн элэгдлийг:

Дт Элэгдлийн зардал
Кт Хуримтлагдсан элэгдэл

8. Урт хугацаат хөрөнгө оруулалт

8.1 Урт хугацаат хөрөнгө оруулалтад эргэлтийн бус өмчийн үнэт цаас, хараат компанийн энгийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт, бонд барьцаалал, өрийн бичиг зэрэг өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт, бонд эргэлтээс гаргах, хувьцаа худалдан авах зэрэг бусад зорилго бүхий сан, үнэ цэнийг өсгөх зорилгоор эзэмшиж байгаа үндсэн хөрөнгө, нэгдсэн компанид олгосон урьдчилгаа,нөхөрлөл болон хамтарсан үйлдвэрт оруулсан өмч, зээл ба эд хөрөнгийн хувь оролцоо гэх мэт төрөл бүрийн бусад хөрөнгө оруулалт багтана. Урт хугацаат хөрөнгө оруулалтыг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

- 22 100 - Урт хугацаат үнэт цаас
- 22 200 - Салбарт оруулсан хөрөнгө оруулалт
- 22 300 - Бусад урт хугацаат хөрөнгө оруулалт

8.2 Үнэлгээ: Урт хугацаат хөрөнгө оруулалтыг ихэвчлэн олж бэлтгэсэн өртгөөр нь дансанд бүртгэдэг. Урт хугацаат хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэ цэнэ буурч байгаа тохиолдолд үнийн бууралтыг хөрөнгө оруулалт тус бүрээр тодорхойлж балансад хүлээн зөвшөөрч тусгадаг.

8.3 Бүртгэл: Урт хугацаат хөрөнгө оруулалтыг бүртгэх жишээг үзүүлэв.

Үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулалтыг:

Дт Урт хугацаат үнэт цаас
Кт Мөнгөн хөрөнгө

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ

Өр төлбөр гэдэг нь төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөжид биелэлээ олсон аж ахуйн нэгжийн нөөц гадагш урсахаар хүлээгдэж байгаа, өнгөрсөн үйл явдлын дүнд үүссэн өнөөгийн үүрэг хариуцлага юм. Барагдуулах хугацаа шинж чанараас нь хамааруулан өр төлбөрийг богино болон урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

9. Богино хугацаат өр төлбөр

9.1 Үүнд аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн үйл ажиллагааны ердийн циклээс үүссэн өр төлбөр бөгөөд балансын өдрөөс хойш 12 сарын дотор төлөгдөх ёстой өр төлбөрүүд хамаарна. Богино хугацаат өр төлбөрийг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

- 31 100 - Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг (нүүрс, мазутын өглөг г.м.)
- 31 150 - Хүүгийн өглөг (богино ба урт хугацаат зээлийн хүү)
- 31 200 - Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч
- 31 210 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч
- 31 220 - Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч
- 31 230 - Диспетчерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч
- 31 300 - Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын өглөг
- 31 400 - Хүн амын орлогын албан татварын өглөг
- 31 410 - Үйлдвэрчний эвлэлийн татварын өглөг
- 31 420 - Гаалийн татварын өглөг
- 31 430 - Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын өглөг
- 31 440 - Бусад татварын өглөг
- 31 490 - Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг
- 31 500 - Ногдол ашгийн өглөг
- 31 600 - Цалингийн өглөг
- 31 700 - Богино хугацаат зээлийн өглөг
- 31 710 - Векселийн өглөг
- 31 800 - Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг
- 31 900 - Бусад богино хугацаат өр төлбөр

9.2 Бүртгэл: Богино хугацаат өр төлбөрийг бүртгэх жишээг үзүүлэв.

Богино хугацаат зээл авсан бол:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Богино хугацаат зээлийн өглөг

Богино хугацаат зээлийн хүүг төлбөл:

Дт	Хүүгийн зардал: богино хугацаат өр төлбөр
Кт	Мөнгөн хөрөнгө

Урт хугацаат зээлийн тайлангийн жилд төлөгдөх хэсгийг бүртгэхдээ:

Дт	Урт хугацаат зээлийн өглөг
Кт	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг

Татварын зардлыг бүртгэхдээ:

Дт	Татварын зардал
Кт	Бусад татварын өглөг

Урьдчилж орсон орлогыг бүртгэхдээ:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Бусад өглөг /Урьдчилж орсон орлого/

10. Урт хугацаат өр төлбөр

10.1 Богино хугацаат өр төлбөрөөс бусад өр төлбөрийг үүнд бүртгэнэ. Урт хугацаат өр төлбөрийг дараах дансны нэгдсэн жагсаалтын дансуудад бүртгэнэ.

32 100 - Урт хугацаат векселийн өглөг
 32 200 - Урт хугацаат зээлийн өглөг
 32 300 - Бондын өглөг
 32 310 - Бондын хөнгөлөлт, урамшуулал
 32 400 - Хойшлогдсон кредит ба бусад урт хугацаат өр төлбөр

10.2 Бүртгэл: Урт хугацаат өр төлбөрийг бүртгэх жишээг үзүүлэв.

Урт хугацаат зээл тусламж авбал:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Урт хугацаат зээлийн өглөг

Зээлийн тайлант үед тооцсон хүүгийн зардлын хэмжээгээр:

Дт	Хүүгийн зардал: урт хугацаат өр төлбөр
Кт	Хүүгийн өглөг / мөнгөн хөрөнгө

Бондыг хөнгөлөлттэй гаргавал:

Дт	Мөнгөн хөрөнгө
	Бондын хөнгөлөлт
Кт	Бондын өглөг

Бондыг урамшуулалтай гаргавал:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Бондын өглөг
	Бондын урамшуулал

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ

11. Эзэмшигчийн өмч

11.1 Өмч гэдэг нь бүх өр төлбөрөө барагдуулсны дараа аж ахуйн нэгжид үлдэж байгаа хөрөнгө юм. Компанийн зохион байгуулалттай аж ахуйн нэгжийн хувьд өмчийн хэлбэр нь хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчийн өмчийг дансны нэгдсэн жагсаалтын дараах дансуудад бүртгэнэ.

41 100 - Энгийн хувьцаа
 41 110 - Давуу эрхтэй хувьцаа
 41 120 - Халаасны хувьцаа
 41 130 - Нэмж төлөгдсөн капитал
 41 200 - Төсөвлөсөн хуримтлагдсан ашиг
 41 210 - Хуримтлагдсан ашиг
 41 300 - Дахин үнэлгээний нэмэгдэл

11.2 Бүртгэл: Эзэмшигчийн өмчийг бүртгэх жишээг үзүүлэв.

Нэрлэсэн үнээс илүү үнээр хувьцаа борлуулсан бол:

Дт	Мөнгөн хөрөнгө
Кт	Энгийн хувьцаа
	Нэмж төлөгдсөн капитал

Нэрлэсэн үнэгүй хувьцаа борлуулсан бол:

Дт Мөнгөн хөрөнгө
Кт Энгийн хувьцаа

Төсөвлөсөн хуримтлагдсан ашиг гэдэг нь тусгай зорилгоор ашиглахаар хязгаарласан хөрөнгийг хэлнэ. Хуримтлагдсан ашгийн хэсгийг төсөвлөх бол:

Дт Хуримтлагдсан ашиг
Кт Төсөвлөсөн хуримтлагдсан ашиг

ТАВДУГААР БҮЛЭГ ОРЛОГЫН БҮРТГЭЛ

12. Орлого

12.1 Байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт хэлбэрээр илэрсэн, эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын борлуулалтын орлогыг хэрэглэгчдийн ангиллаас хамааран дансны нэгдсэн жагсаалтад дараах дансуудад бүртгэнэ. Үүнд ирээдүйд батлагдах 2 шатлалтай тарифын аргачлалыг дэмжсэн дансууд орсон. Хэрэв үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч эцсийн хэрэглэгчдэд шууд борлуулалт хийвэл холбогдох хэрэглэгчийн дансуудад орлогыг тусгана.

51 110 - Хэрэглэгч: Оршин суугч, ахуйн хэрэглэгчид
51 120 - Хэрэглэгч: Худалдаа, үйлчилгээний байгууллага
51 121 - Худалдаа үйлчилгээний байгууллага-400В
51 122 - Худалдаа үйлчилгээний байгууллага-10/6 КВ
51 130 - Хэрэглэгч: Үйлдвэрлэлийн байгууллага
51 131 - Үйлдвэрлэлийн байгууллага-400В
51 132 - Үйлдвэрлэлийн байгууллага-10/6 КВ
51 133 - Үйлдвэрлэлийн байгууллага-35КВ
51 140 - Хэрэглэгч: Төсвийн байгууллага
51 200 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого
51 210 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн чадлын борлуулалт
51 220 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энергийн борлуулалт
51 230 - Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дулааны борлуулалт
51 300 - Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого
51 400 - Хүү, торгуулийн орлого
51 500 - Бусад орлого

Үйл ажиллагааны бус орлогыг дараах дансуудад бүртгэнэ.

84 100 - Хүүгийн орлого
84 200 - Торгуулийн орлого
